

Ажлын баримт: 3001

Аудит хийгдсэн нэгж:
Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд



- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Хамрах хугацаа: 2023/01/01-2023/11/30

2024 ОН

АУДИТЫН ТУХАЙ

ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:	Аудит №НДЕГ-ДАМГ-2023/02-НА
АУДИТ ХИЙГДСЭН НЭГЖ:	Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд
АУДИТ ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
АУДИТЫН ТӨРӨЛ :	Нийцлийн аудит
ХАМРАХ ХУГАЦАА :	2023/01/01-2023/11/30
ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА:	2023/12/27-2024/01/14

ТАНИЛЦСАН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА
Л. МӨНХЗУЛ

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН
ДАРГА
Б.ДАВААХҮҮ

ХЯНАСАН

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН ДАРГА
Б.ГАНХУЯГ

ГҮЙЦЭТГЭСЭН:
ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Н.БОЛОРМАА

Э.ЦОЛМОН

Ц.ҮЗМЭЭ

О.ОЮУНЦЭЦЭГ

АЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ТАСАГ (ГАЗАР)-ИЙН
БАЙЦААГЧ НАР

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛТ БА ХАМРАХ ХҮРЭЭ
 - 2.1 Аудитын зорилго
 - 2.2 Аудитын хамрах хүрээ
 - 2.3. Арга аргачлал
3. АУДИТЫН ҮР ДҮН
4. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН АЛДАА ДУТАГДАЛ
5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ
6. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. ТАНИЛЦУУЛГА

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа 34 байгууллага, Нийгмийн даатгалын сангийн 32 хэрэглэгчээр шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хандан Төсөв, гүйцэтгэл төрөлд 11, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт төрөлд 4, Бусад гэсэн цэсээр 7, нийт 22 төрлийн мэдээллийг байршуулан нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн мэдээлэлтэй танилцах боломжийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.7 дахь заалт, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/197 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитын ажлын тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэс, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын газруудын хийж гүйцэтгэсэн аудитын танилцуулга, тоон мэдээллийг хянаж нэгтгэн бэлтгэлээ.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Зорилго

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох баримт бичгийг бүрэн оруулсан байдалд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх, гаргасан алдаа, илэрсэн зөрчлийг арилгуулахад гол зорилго оршино.

2.2. Хамрах хүрээ

Аудитад Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг дуусталх хугацааны мэдээлэл байршуулалт болон өмнөх онд Үндэсний аудитын газраас шилэн дансны мэдээлэл байршуулалтад өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт, хэрэгжилтийг хамрууллаа.

2.3. Арга аргачлал

Аудитыг гүйцэтгэхэд байгууллагын цахим хуудаст байршуулсан мэдээллийг харилцах дансны хуулга, мөнгөн хөрөнгө зарцуулах тухай А, Б тушаал, батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, холбогдох сарын мэдээ, 2022 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын дүгнэлт зэрэгт үндэслэн дүн шинжилгээ хийх, байршуулсан мэдээ, мэдээллийг баримтаар тулган шалгах, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох баримт цуглуулах арга замаар хэрэгжүүлээ.

Аудитыг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;
2. Мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан эсэх;

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

3. Өмнөх онд аудитын дүгнэлтээр шилэн дансны мэдээлэл байршуулалтад өгсөн албан шаардлага зөвлөмжийг биелүүлсэн эсэх;

Аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримт бичгийг эх үүсвэр болгон ашиглалаа. Үүнд:

- Захиргааны ерөнхий хууль;
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

3. АУДИТЫН ҮР ДҮН

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд нь Shilendans.gov.mn цахим хуудсанд Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа болон Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг тухай бүр, сар, улирал, хагас жил, жилээр гэсэн давтамжтайгаар мэдээлж байна

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд нийт 9,739 мэдээлэл байршуулахаас 9,320 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 365 мэдээллийг хугацаа хоцроож, 54 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулалт 99.4 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 95.7 хувьтай байна. /Дүн мэдээг хавсралт № 1, 2-оор харуулав./

Үүнд:

- **Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:** 5,168 мэдээлэл байршуулахаас 4,988 мэдээллийг хугацаанд нь байршуулж 162 мэдээллийг хугацаа хоцроож, 18 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулалт 99.7 хувь, хугацаанд нь байршуулсан мэдээлэл 96.52 хувь; /Дүн мэдээг хавсралт № 3,4-өөр харуулав./

- **Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт:** 4,571 мэдээлэл байршуулахаас 4,332 мэдээллийг байршуулж 203 мэдээллийг хугацаа хоцроож, 36 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулалт 99.2 хувь, хугацаанд нь байршуулсан мэдээлэл 94.5 хувь; /Дүн мэдээг хавсралт № 5,6-аар харуулав./

Нийгмийн даатгалын салбарын дүнгээр нийт мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргээр харуулбал:

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

№	Байгууллагын нэр	Нийт мэдээллэх	Мэдээлэл хугацаандаа оруулсан	Үүнээс				Хугацаа хоцорсон мэдээлэл	Үүнээс			Мэдээлэл оруулаагүй	Нийт мэдээлэл байршуулсан хувь	Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь
				Мэдээлэл хугацаандаа оруулсан	Ил тод болгоогүй /Мэдээлэл оруулж байгаа/	Ил тод болгосон /Араас нь хугацаандаа зассан/	Оруулах мэдээлэл байхгүй		Хугацаа хоцроосон	Оруулах мэдээлэл байхгүй	Ил тод болгосон /хоцорч зассан/			
1	НДЕГаар	152	150	89	-	2	59	2	2	-	-	-	100%	99%
2	МТТөв	152	150	73	-	-	77	2	2	-	-	-	100%	99%
3	БНСУ дахь НД-ын тасаг	152	140	54	-	2	84	12	4	8	-	-	100%	92%
5	ННДГ	174	173	78	-	2	93	1	1	-	-	-	100%	99%
6	Баянгол	304	302	112	-	14	176	2	2	-	-	-	100%	99%
7	Баянзүрх	304	296	99	-	7	190	8	3	4	1	-	100%	97%
8	Сүхбаатар дүүрэг	304	299	117	-	6	176	5	4	-	1	-	100%	98%
9	Сонгинохайрхан	304	296	117	1	10	168	8	8	-	-	-	100%	97%
10	Чингэлтэй	304	301	147	-	2	152	3	-	-	3	-	100%	99%
11	Хан-Уул	304	302	302	-	-	-	2	2	-	-	-	100%	99%
12	Налайх	304	301	139	-	-	162	3	2	1	-	-	100%	99%
13	Багануур	304	293	118	-	2	173	11	11	-	-	-	100%	96%
14	Багахангай	293	281	130	3	118	30	12	12	-	-	-	100%	96%
15	Архангай	304	300	133	-	9	158	4	2	-	2	-	100%	99%
16	Баян-Өлгий	304	300	103	-	10	187	4	4	-	-	-	100%	99%
17	Баянхонгор	304	299	131	5	7	156	5	4	-	1	-	100%	98%
18	Булган	304	304	132	-	18	154	-	-	-	-	-	100%	100%
19	Говь-Алтай	304	283	72	-	5	206	21	11	10	-	-	100%	93%
20	Говьсүмбэр	304	281	62	-	7	212	23	18	2	3	-	100%	92%
21	Дархан-Уул	304	288	89	1	4	194	16	15	1	-	-	100%	95%
22	Дорноговь	304	291	90	14	3	184	13	4	9	-	-	100%	96%
23	Дорнод	304	298	154	-	5	139	6	4	2	-	-	100%	98%
24	Дундговь	304	297	136	-	2	159	7	3	4	-	-	100%	98%
25	Завхан	304	279	114	-	5	160	25	12	4	9	-	100%	92%
26	Орхон	304	298	113	-	2	183	6	3	2	1	-	100%	98%
27	Өвөрхангай	304	296	85	28	2	181	8	8	-	-	-	100%	97%
28	Өмнөговь	304	287	120	-	4	163	17	16	-	1	-	100%	94%
29	Сүхбаатар	304	304	123	-	2	179	-	-	-	-	-	100%	100%
30	Сэлэнгэ	304	285	91	-	1	193	19	5	14	-	-	100%	94%
31	Төв	304	202	58	-	3	141	48	16	1	31	54	82%	66%
32	Увс	304	293	127	8	6	152	11	8	3	-	-	100%	96%
33	Ховд	304	297	165	2	1	129	7	7	-	-	-	100%	98%
34	Хөвсгөл	304	294	177	-	3	114	10	3	4	3	-	100%	97%
35	Хэнтий	304	260	260	-	-	-	44	-	-	44	-	100%	86%
Нийт		9,739	9,320	4,110	62	264	4,884	365	196	69	100	54	99.4%	95.7%

Дээрх хүснэгтээс харахад:

- Хугацаандаа байршуулсан 9,320 мэдээллээс:

- ✓ Мэдээллээ хугацаандаа оруулсан 4,110 мэдээлэл;
- ✓ Ил тод болгоогүй /Мэдээлэл оруулж байгаа/ 62 мэдээлэл;
- ✓ Ил тод болгосон /Дараа нь хугацаандаа зассан 264 мэдээлэл;
- ✓ Оруулах мэдээлэл байхгүй төлөвт оруулсан 4,884 мэдээлэл байна.

- Хугацаа хоцроож байршуулсан 365 мэдээллээс:

- ✓ Хугацаа хоцроосон 196 мэдээлэл;
- ✓ Оруулах мэдээлэл байхгүй төлөвт 69 мэдээлэл;
- ✓ Ил тод болгосон /хоцорч зассан/ 100 мэдээлэл байна.

Мэдээллийг хугацаандаа оруулж байгаа боловч мэдээллийг ил тод болгоогүй 62 мэдээлэл, араас нь ил тод болгож зассан 264 мэдээлэл, хугацаандаа байршуулсан оруулах мэдээлэл байхгүй төлөвт оруулсан 4,884 мэдээлэл, мөн ил тод болгож хугацаа хоцорч зассан 100 мэдээлэл хугацаа хоцроосон оруулах мэдээлэл байхгүй төлөвт байгаа 69 мэдээлэл байгаа нь цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлээгүй, оруулах ёстой мэдээллийг байршуулаагүй буюу дутуу мэдээлсэн байгааг харуулж байна.

Шалгуур 1. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг бүрэн байршуулсан эсэх асуудлын хүрээнд:

Илэрсэн асуудал 1: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг мэдээлж байршуулаагүй буюу дутуу мэдээлсэн.

Асуудлын ангилал: Нөлөө ихтэй.

Бодит байдал: Байршуулах ёстой мэдээллийг мэдээлээгүй 54 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 0.55 хувийг эзэлж байна. Үүнд:

- **Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа:** Мэдээллийг байршуулаагүй буюу мэдээлээгүй 18 мэдээлэл (Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс);
- **Нийгмийн даатгалын сан:** Мэдээллийг байршуулаагүй буюу мэдээлээгүй 36 мэдээлэл (Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс);

Мэдээллийг мэдээлсэн боловч дутуу мэдээллэсэн 2,364,267.4 сая төгрөгийн 9,173 шийдвэр, гүйлгээ байна. Энэ нь нийт мэдээлбэл зохих мэдээллийн /Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх/ 5.0 хувийг эзэлж байна. Үүнд:

- **Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа:** Мэдээллийг мэдээлсэн боловч дутуу мэдээлсэн 6,060.7 сая төгрөгийн 175 шийдвэр, гүйлгээ байна. Энэ нь нийт мэдээлбэл зохих мэдээллийн /Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх/ 1.97 хувийг эзэлж байна (**БНСУ**лс **ХНХҮТөвийн** Нийгмийн даатгалын тасаг, Баянгол, Сүхбаатар дүүрэг, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс);
- **Нийгмийн даатгалын сан:** Мэдээллийг дутуу мэдээлсэн 2,358,206.6 сая төгрөгийн 8,998 шийдвэр, гүйлгээ байна. Энэ нь нийт мэдээлбэл зохих мэдээллийн /Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх/ 5.02 хувийг эзэлж байна. (Баянгол, Сүхбаатар дүүрэг,

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс);

Мэдээлээгүй буюу цахим хуудсанд дутуу байршуулсан мэдээллийг аймаг дүүргээр харуулбал:

/мян төг/

№	Байгууллагын нэр	Нийт мэдээлэх	Мэдээлээгүй	Мэдээлэх		Мэдээлээгүй		Нийт мэдээлэл байршуулалт /хувьар/
				Мөнгөн дүн	Шийдвэр гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Шийдвэр гүйлгээний тоо	
1	БНСУ дахь НД-ын тасаг	152	-	8,807,464	32	13,358	1	0.15%
2	Баянгол	304	-	7,042,356,607	15,669	960,972	7	0.01%
3	Сүхбаатар дүүрэг	304	-	5,704,995,351	19,155	65,414,215	63	1.15%
4	Баянхонгор	304	-	552,497,027	2,406	218,797,669	2	39.60%
5	Булган	304	-	460,286,609	463	118,452,989	10	25.73%
6	Говьсүмбэр	304	-	99,563,875	143	25,926,909	70	26.04%
7	Дархан-Уул	304	-	1,538,510,193	4,199	751,058,191	1,081	48.82%
8	Өвөрхангай	304	-	982,781,293	809	271,132	33	0.03%
9	Өмнөговь	304	-	1,427,120,438	6,430	59,589,488	743	4.18%
10	Сүхбаатар	304	-	598,340,287	4,401	71,968,546	39	12.03%
11	Сэлэнгэ	304	-	1,213,483,596	3,210	318,235	3	0.03%
12	Төв	304	54	883,000,334	9,247	818,502,490	5,802	92.70%
13	Увс	304	-	805,948,573	87	234,035	17	0.03%
14	Хэнтий	304	-	938,967,396	6,400	232,759,219	1,302	24.79%
Нийт			54	47,428,565,378	155,342	2,364,267,447	9,173	5.00%

Мэдээлээгүй буюу цахим хуудсанд дутуу мэдээлсэн мэдээллийг төрлөөр харуулбал:

/мян төг/

Мэдээллийн төрөл	Мэдээлээгүй				Нийт мэдээлээгүй	Нийт мэдээлэх дүнд эзлэх хувь
	Нийгмийн даатгалын байгууллага		Нийгмийн даатгалын сан			
	Мөнгөн дүн	Шийдвэр гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Шийдвэр гүйлгээний тоо		
ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ ангилалд						
Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-Эдийн засгийн ангилал	274,824.8	11	255,610,912.8	115	255,885,737.6	3.49%
Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт	738,010.1	4	334,573,936.2	126	335,311,946.3	4.57%
Санхүүгийн тайлан	-	-	18,840,805.0	1	18,840,805.0	0.81%
Байгууллагын батлагдсан төсөв	-	-	277,887,030.4	2	277,887,030.4	3.96%

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Дараа жилийн төсвийн төсөл	-	-	2,980,469	1	2,980,469	0.04%
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	1,048,185.2	49	379,436,469.0	3,645	380,484,654.2	6.74%
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	1,050,076	72	444,460,812.5	5,082	445,510,888.7	7.14%
Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	2,873,812.5	1	644,413,316.8	13	647,287,129.3	15.68%
БУСАД ангилалд						
Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	399.7	1	2,922.3	13	3,322.0	0.01%
Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	62,106.4	36			62,106.4	0.07%
Нийт	6,060,772.9	175	2,358,206,674.0	8,998	2,364,267,447	5.00%

Үр нөлөө: Хэрэглэгчдэд буруу ойлголт төрүүлэх, удирдлага албан тушаалтан хариуцлага тооцуулах, хуулийг мөрдөж ажиллаагүй дүгнэлт авах эрсдэлтэй;

Зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг үнэн зөв бүрэн байршуулсан байх;

Шалгуур 2. Нийгмийн даатгалын төв₂ орон нутгийн байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан эсэх асуудлын хүрээнд:

Илэрсэн асуудал 2: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

Асуудлын ангилал: Их нөлөөтэй.

Бодит байдал: Байршуулах ёстой мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 365 мэдээлэл байгаа нь нийт байршуулах мэдээллийн 3.74 хувийг эзэлж байна. Үүнд:

- **Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа:** Байршуулах ёстой мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 162 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

мэдээллийн 3.13 хувь(Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Хан-Уул дүүрэг, Булган, Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын газраас бусад хэлтэс)-г;

- **Нийгмийн даатгалын сан:** Байршуулах ёстой мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 203 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 4.44 хувь (Булган, Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын газраас бусад газраас бусад хэлтэс)-г эзэлж байна.

Хугацаа хоцроож байршуулсан 4,313,902.5 сая төгрөгийн 2,272 шийдвэр, гүйлгээ байна. Энэ нь нийт мэдээлэл зохих мэдээллийн /Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх/ 9.12 хувийг эзэлж байна. Үүнд:

- **Нийгмийн даатгалын байгууллага:** Хугацаа хоцроож байршуулсан 30,482.6 сая төгрөгийн 171 шийдвэр, гүйлгээ байна. Энэ нь нийт мэдээлэл зохих мэдээллийн /Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх/ 9.92 хувийг эзэлж байна (БНСУ-д дахь ХНХҮТөвийн Нийгмийн даатгалын тасаг, Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Налайх, Багануур, Багахангай, Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс);
- **Нийгмийн даатгалын сан:** Хугацаа хоцроож байршуулсан 4,283,419.9 сая төгрөгийн 2,100 шийдвэр, гүйлгээ байна. Энэ нь нийт мэдээлэл зохих мэдээллийн /Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх/ 9.11 хувийг эзэлж байна (Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх, Багануур, Багахангай дүүрэг, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс)

Цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан мэдээллийг аймаг, дүүргээр харуулбал:

/Мян төг/

№	Байгууллагын нэр	Нийт мэдээлэх	Хугацаа хоцроосон	Мэдээлэх		Хугацаа хоцроосон		Нийт мэдээлэл байршуулалт
				Мөнгөн дүн	Шийдвэр гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Шийдвэр гүйлгээний тоо	
1	НДЕГаар	152	2	33,363,905	244	-	-	
2	МТТөв	152	2	6,425,874	75	-	-	
3	БНСУ дахь НД-ын тасаг	152	12	8,807,464	32	2,065,616	2	23.45%
4	ННДГ	174	1	590,639,580	73	133,986,865	1	22.69%
5	Баянгол	304	2	7,042,356,607	15,669	805,775,646	2	11.44%
6	Баянзүрх	304	8	4,170,204,378	13,838	850,610	4	0.02%
7	Сүхбаатар дүүрэг	304	5	5,704,995,351	19,155	821,495,262	3	14.40%
8	Сонгинохайрхан	304	8	3,537,764,982	628	349,328,317	8	9.87%
9	Чингэлтэй	304	3	1,831,092,811	1,155	213,829,353	2	11.68%
10	Хан-Уул	304	2	4,786,694,731	14,802	-	-	0.00%
11	Налайх	304	3	190,974,213	171	15,849,824	2	8.30%
12	Багануур	304	11	466,634,911	1,209	97,213,428	8	20.83%
13	Багахангай	293	12	63,118,091	126	118,917	11	0.19%
14	Архангай	304	4	855,749,258	108	177,451,027	4	20.74%

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

15	Баян-Өлгий	304	4	890,676,380	5,896	118,912,668	2	13.35%
16	Баянхонгор	304	5	552,497,027	2,406	159,324,758	1	28.84%
17	Булган	304	-	460,286,609	463	-	-	0.00%
18	Говь-Алтай	304	21	447,492,055	10,649	134,283,562	10	30.01%
19	Говьсүмбэр	304	23	99,563,875	143	4,068,818	23	4.09%
20	Дархан-Уул	304	16	1,538,510,193	4,199	-	1	0.00%
21	Дорноговь	304	13	775,984,903	5,468	183,090,143	1	23.59%
22	Дорнод	304	6	1,102,142,487	7,518	178,770,687	2	16.22%
23	Дундговь	304	7	356,661,812	95	69,179,907	4	19.40%
24	Завхан	304	25	574,702,849	1,186	4,291,837	3	0.75%
25	Орхон	304	6	1,905,534,597	4,168	15,696,020	58	0.82%
26	Өвөрхангай	304	8	982,781,293	809	167,345	6	0.02%
27	Өмнөговь	304	17	1,427,120,438	6,430	293,630,740	16	20.58%
28	Сүхбаатар	304	-	598,340,287	4,401	-	-	0.00%
29	Сэлэнгэ	304	19	1,213,483,596	3,210	846,446	8	0.07%
30	Төв	304	48	883,000,334	9,247	242,416,045	2,063	27.45%
31	Увс	304	11	805,948,573	87	128,092,264	7	15.89%
32	Ховд	304	7	903,855,473	6,801	162,719,539	7	18.00%
33	Хөвсгөл	304	10	1,553,372,346	8,481	525	6	0.00%
34	Хэнтий	304	44	938,967,396	6,400	446,404	6	0.05%
		9,739	365	47,299,744,682	155,342	4,313,902,570	2,271	9.12

Цахим хуудсанд хугацаа хоцроосон мэдээллийг төрлөөр харуулбал:

/Мян төг/

Мэдээллийн төрөл	Хугацаа хоцроосон				Нийт хугацаа хоцроож байршуулсан мөнгөн дүн	Нийт мэдээлэх дүнд эзлэх хувь
	Нийгмийн даатгалын байгууллага		Нийгмийн даатгалын сан			
	Мөнгөн дүн	Шийдвэр гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Шийдвэр гүйлгээний тоо		
ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ ангиалд:						
Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-Эдийн засгийн ангилал	2,652,816	22	18,178,101	15	20,830,917	0.28%
Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт	4,103,024	71	28,934,862	14	33,037,886	0.45%
Санхүүгийн тайлан	2,334,186	4	90,683,767	6	93,017,953	4.02%
Байгууллагын батлагдсан төсөв	-	-	183,248,834	1	183,248,834	2.61%
Дараа жилийн төсвийн төсөл	18,462,372	12	3,025,081,916	15	3,043,544,288	45.49%
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	259,723	2	54,887,596	1,043	55,147,319	0.98%
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	20,469	3	61,071,952	991	61,092,420	0.98%
Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	1,559,239	1	686,666,173	3	688,225,412	16.67%

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

<i>БУСАД ангилалд</i>							
Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	899,584	19	679,864	6	1,579,449	32.74%	
Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	191,228	26	-	-	191,228	2.35%	
Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл**			10	133,986,865	133,986,865	22.96%	
Нийт	30,482,639	172	4,283,419,931	2,100	4,313,902,570	9.12%	

Үр нөлөө: Хэрэглэгчдэд буруу ойлголт төрүүлэх, удирдлага албан тушаалтан хариуцлага тооцуулах, хуулийг мөрдөж ажиллаагүй дүгнэлт авах эрсдэлтэй;

Зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд нь бүрэн байршуулсан байх;

Шалгуур 3. Өмнөх онд аудитын дүгнэлтээр өгсөн албан шаардлага зөвлөмжийг биелүүлсэн эсэх асуудлын хүрээнд:

Илэрсэн асуудал 3: Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалтад тавих хяналт сул, аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. /Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хавсралт № 7- оор харуулав./

Бодит нөхцөл байдал: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд өгсөн аудитын дүгнэлтээр Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн, нөхөн мэдээлсэн, мэдээлээгүй зэрэг зөрчилд Говьсүмбэр, Завхан, Өмнөговь аймаг, Сүхбаатар, Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагаа, БНСУ-д дахь ХНХҮ-ний төвийн нийгмийн даатгалын тасагт албан шаардлага, Булган, Орхон, Төв аймаг, Налайх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг аудитын дүн мэдээнд үндэслэн нягтлахад зөвлөмж, албан шаардлагын биелэлт хэрэгжээгүй, 2023 оны эхний 11 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийг бүрэн байршуулаагүй, оруулсан мэдээлэл хоосон зэрэг дутагдал, зөрчил давтан гарч байгаа нь албан шаардлага, зөвлөмжийн биелэлт хангалтгүй байгааг харуулж байна.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй болон мэдээлэл байршуулалт хангалтгүй Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Ховд, Төв аймгийн Нийгмийн

даатгалын хэлтсийн дарга нарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай” 01/773, 01/774, 01/790, 01/791, 01/792 дугаар албан бичгээр, мөн 2023 оны 03 дугаар улирлын мэдээгээр Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулаагүй Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст “Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай” 03/1861 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлсэн.

Мөн Шилэн дансны цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбогдуулан уг цахим системд Нийгмийн даатгалын хэлтсүүдийн шилэн дансны мэдээлэл хариуцсан админ эрхтэй ажилтнууд мэдээлэл оруулах тохиргоог дутуу хийсний улмаас мэдээлэл оруулах цэс байхгүй, зарим мэдээллийг байршуулаагүй байсан тул Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт тохиргоог хийж, мэдээллийг байршуулах, шилэн дансны цахим системтэй холбоотой тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг ирүүлэх талаар Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2023 оны 03/758 дугаар албан бичгийг хүргүүлж ажилласан.

Үр нөлөө:

- Мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, хугацаанд нь байршуулаагүй болон түүнд тавих хяналт сул байгаас хэрэглэгч бодит мэдээллийг хүссэн цаг хугацаанд нь авч чадахгүй байх;
- Удирдлага албан тушаалтан хариуцлага тооцуулах;
- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй дүгнэлт авах эрсдэлтэй байна.

Зөвлөмж:

- Аудитын дүгнэлтээр өгөгдсөн алдаа дутагдал, зөрчлийг тухай бүр арилгах, давтан гаргахгүй байх;

4. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН АЛДАА ДУТАГДАЛ

- Хэрэглэгчийн зүгээс мэдээллийг хугацаандаа байршуулсан харагдах боловч доторх мэдээлэлд нэвтрэхэд мэдээлэл хоосон буюу мэдээллийг байршуулаагүй, мөн дутуу мэдээлсэн;
- Мэдээллийг хугацаанд нь болон хугацаа хоцроож байршуулсан боловч мэдээллийг PDF, Ексел файлаар байршуулаагүй;
- Хэрэглэгчийн Шилэн дансны мэдээлэл татаж авах, хэвлэх боломжийг хангаагүй;
- Мэдээллийг хугацаанд нь болон хугацаа хоцроож байршуулсан хэдий ч оруулсан PDF, Ексел файл нь татагдахгүй байх;
- Сар бүр байршуулах мэдээллийг оруулах мэдээлэл байхгүй төлөвөөр мэдээлсэн;
- Өмнөх сарын мэдээллийг дараа сард давтан оруулж мэдээлсэн;
- Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, нийгмийн даатгалын сангийн мэдээллийг хооронд нь андуурч мэдээлсэн зэрэг алдаа гарч байгаа нь мэдээллийн үнэн зөв, бодитой байх зарчмыг алдагдуулсан байна.

Мэдээллийг мэдээлэхгүй, хугацаа хоцроож байгаа нь дараах шалтгаантай байна.

Үүнд:

- Мэдээлэл оруулах үүрэг бүхий ажилтнуудын шилжилт хөдөлгөөн буюу ажлаас чөлөөлөгдөх, өөрчлөгдөх, мөн жирэмсний болон амаржсаны тэтгэмж, хүүхдээ асрах хугацаанд ажил үүрэг цалгардах;

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

- Удирдах албан тушаалтан болон шинээр томилогдсон албан тушаалтан болон Шилэн дансны тухай хууль, шилэн дансны мэдээлэл байршуулах талаарх ойлголт хангалтгүй, үнэн зөв мэдээлэл байршуулахад бус хариуцлагын арга хэмжээ авхуулахгүйн тулд мэдээллийг байршуулдаг хандлагатай;
- 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шилэн дансны цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой сангийн болон үйл ажиллагааны нягтлан бодогч нарын нэвтрэх эрхийн тохиргоог админ нь хийгээгүй, шилэн дансны цахим хуудасны мэдээлэх цэсийн төрлийн тохиргоог дутуу хийсэн;
- Цахим хуудсанд мэдээлэл байршуулах хуулийн хугацаа богино байгаа нь мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлэхэд хангалтгүй;
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахад интернэтийн хурд удаан тул гацах, уншаад нэвтрэхгүй удах зэргээс шалтгаалж цаг хугацаа их шаардагдаж, мэдээлэл дутуу болон байршаагүй тохиолдол гардаг;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ нь төрийн сангаас бусад арилжааны банкаар хийгдсэн гүйлгээг харилцахын хуулганаас татах боломжгүй тул мэдээ мэдээллийг тогтоосон хугацаанд гараар шивж байршуулахад хугацаа их зарцуулдаг;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг төрийн сангийн И-хуулга татахад зарим саруудад татах мэдээлэл алга гэсэн мэдэгдэл ирж, алдаа гардагтай холбоотой байна.

4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

1. Дотоод аудитаар нийт 2,364,267.4 сая төгрөгийн 365 мэдээллийг хугацаа хоцроосон, 4,313,902.5 сая төгрөгийн 54 мэдээллийг мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цахим хуудсанд мэдээлэл байршуулах ажлыг “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэж байна.

2. Шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь мэдээлэл байршуулалт 59-100 хувьтай харагдаж байгаа боловч доторх мэдээллийг түүвэрлэн нягтлахад мэдээлэл үнэн зөв, бодитой байх зарчим алдагдаж, мэдээллийн чанар хангалтгүй байгааг харагдаж байна.

3. Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бодитой мэдээлэх хувийг 100 хувьд хүргэх, мөн Төв, Говь-Алтай, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулахад онцгой анхаарах шаардлагатай байна.

Нийслэлийн Нийгмийн даатгалын газар удирдамжид заасан хугацаанд тоон мэдээг үнэн зөв, бодитой гаргаж өгөөгүй, аудитын дүн мэдээний үндэслэлд хяналт тавиагүй, мэргэжил арга зүйгээр хангаагүй, нийслэлийн хэмжээний нэгдсэн дүн, танилцуулга ирүүлээгүй, удаа дараа шаардуулах, албан хаагчид миний хийх ажил биш гэх зэргээр ажилд хандах хандлага, дотоод зохион байгуулалтыг хийж ажиллаагүй нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх дотоодын хяналт, албан хаагчдын ажлын хариуцлага, мэдлэг чадвар, ажилд хандах хандлага сул байгааг харуулж байна гэж дүгнэлээ.

5. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж, алдаа дутагдал, зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдээлэл байршуулалтыг үнэн зөв, бүрэн хуулийн хугацаанд мэдээлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

6.1. Тамгын газарт:

- 6.1.1. Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах, хяналт тавих ажил үүргийг тусган хариуцлагажуулах;
- 6.1.2. Аудитын тайланг үндэслэн гаргасан саналын дагуу ажилдаа хариуцлагагүй, хайнга хандсан эрх бүхий албан тушаалтанд Шилэн дансны тухай хуулийн 10.1, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 9.1-д заасны дагуу хариуцлага тооцох;

6.2. Санхүү бүртгэлийн газарт:

- 6.2.1. Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулах цэсийн Нийгмийн даатгалын байгууллага, Нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд хамааралтай болон хамааралгүй цэсийн жагсаалт болон байгууллагын онцлог загварт тохирсон маягтын загварыг гаргаж, Дотоод аудит, мониторингийн газарт ирүүлэх;
- 6.2.2. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахтай холбоотой сангийн болон үйл ажиллагааны нягтлан бодогч нарт гарч буй хүндрэл бэрхшээл, санал хүсэлтийг нэгтгэж Дотоод аудит, мониторингийн газарт ирүүлэх;

6.3. Дотоод аудит мониторингийн газарт:

- 6.3.1. Шилэн дансны тухай хууль болон шилэн дансны мэдээлэл байршуулах талаар холбогдох газруудтай хамтран сургалт зохион байгуулах, гарын авлага бэлтгэж нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлэх;
- 6.3.2. Шилэн дансны мэдээлэл байршуулалтад 2024 оны 3 дугаар улиралд гүйцэтгэлийн аудит хийх;
- 6.3.3. Шилэн дансны цахим хуудастай холбоотой санал хүсэлтийг холбогдох газруудад хүргүүлэх;

6.4. Аймаг(Нийслэл), дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт:

- 6.4.1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх;
- 6.4.2. Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, хүргүүлсэн зөвлөмж, чиглэлийг сайтар уншиж, танилцах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 6.4.3. Шилэн дансны цахим хуудасны “Суралцахуй” цэсэнд байршуулсан Шилэн дансны цахим хуудасны сургалт, байгууллагын хэрэглэгчийн гарын авлага, видео хичээлтэй танилцах, суралцах;
- 6.4.4. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах, байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах;
- 6.4.5. Нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын сангийн мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, хуулийн хугацаанд нь бүрэн байршуулсан эсэхэд тогтмол хяналт тавьж хэвших, ажлын үр дүнг тооцох;
- 6.4.6. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээ, мэдээллийг хуулийн

- хугацаанд стандарт, аргачлалын дагуу байршуулах;
- 6.4.7. Шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажиллах ажилтныг томилон ажиллуулах, ажлын үр дүнг тооцох;
- 6.4.8. Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах;
- 6.4.9. Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгаж, мэдээллийн үнэн зөв, хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэхэд хяналт, шалгалтыг хагас, бүтэн жилээр хийж, үр дүнг тооцож ажиллах;

-oOo -

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН
